




Төлөвлөгөө баталсан:


Төсвийн шууд захирагч

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Тэмдэг



(гарын үсэг)

 Л.ЮМЖИРДУЛАМ

.....
(огноо)

Төлөвлөгөөг боловсруулсан:

Нэгжийн дарга

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


.....
(гарын үсэг)

П.МАЙНБАЯР

2025.06.10
.....
(огноо)

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Зорилт 1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;	-	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм журам, тушаал, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зохион байгуулж ажиллалаа. Дээд газраас хүргүүлсэн журам заавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар газрын болон сумдын байцаагч нарт танхимаар 3, цахимаар 8, нийт 11 удаагийн сургалт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 28 дүрэм, журам, заавар, зөвлөмж, чиглэл, албан бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан байна. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дүгээр тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 22193 тэтгэвэр авагчийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн.	(ЗХХ) 100
1.4.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр	-	2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа	-	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж,	Ажил олгогч, иргэд даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгууллаа. Үүнд: 1.Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг	(ЗХХ, СБӨХ,

дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;	хийгдсэн байна.		судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна.	-Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт -Албан хаагчдын үйлчилгээний чанар хүртээмж, -Нийгмийн даатгалын газрын албан хаагчдын ёс зүй, -Тус газрын сургалт сурталчилгаа, -Нийгмийн даатгалын газраас хүргэж байгаа мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдал, -Portal.ndaatgal.mn сайтын ашиглалт гэсэн 7 асуултын хүрээнд, маш сайн, сайн, дунд, муу, хангалтгүй гэсэн асуулгаар сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Судалгаанд нийт 45 ажил олгогч хамрагдсан. Үүнээс: Маш сайн гэсэн асуулгыг сонгосон 51 буюу 16 хувь, сайн гэсэн асуулгыг 164 буюу 52 хувь, дунд гэсэн асуулгыг сонгосон 91 буюу 29 хувь, муу гэсэн асуулгыг сонгосон 6 буюу 2 хувь, хангалтгүй гэсэн асуулгыг сонгосон 3 буюу 1 хувийг тус тус эзлэж байна. Судалгаанд оролцогчдын 68 хувь нь тус газрын ажил үйлчилгээг маш сайн, сайн гэж дүгнэсэн бол 29 хувь нь дунд, 5 хувь нь муу, хангалтгүй гэж дүгнэсэн байна. 2.Даатгуулагчийн сэтгэл ханамжийн судалгааг, -Нийгмийн даатгалын газрын чанар хүртээмж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, албан хаагчдын үйлчилгээний шуурхай байдал, ёс зүй харилцаа хандлага, нээлттэй утасны үйлчилгээ, мэдээллийн ил тод байдал, нийгмийн даатгалын шимтгэл төлөх ач холбогдол гэсэн 7 асуулгын хүрээнд судалгаа авлаа. Судалгаанд нийт 37 даатгуулагч хамрагдсан. Үүнээс маш сайн 97 буюу 38.3 хувь, сайн 88 буюу 34.4, дунд 43 буюу 16.8 хувь, муу 16 буюу 6.3 хувь, хангалтгүй 11 буюу 4.3 хувийг тус тус эзэлж байна. Судалгаанд оролцсон иргэдийн 72.7 хувь нь тус газрын ажил үйлчилгээг маш сайн, сайн гэж дүгнэсэн байна.	ТТХ) 95
Зорилт 3: “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:					
Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод	-	- Мэдээлэл байршуулалт	Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл	Байгууллагын мэдээллийг үнэн зөв,	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу : ДАМГ (Мэдээл

3.1.	байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих;		ыг 100 хувьд хүргэнэ.	байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 94.2 хувийн гүйцэтгэлтэй байна.	бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	8.2.9 дэх заалт сарын мэдээ, статистик мэдээ 8.4.1 дэх заалт Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл 8.4.2-8.4.9 дэх заалтын мэдээллийг бэлтгэн хугацаанд нь вебсайтад байршуулсан мэдээлэлд хяналт тавьж ажилласан. https://huvsgul.ndaatgal.mn/ вэб сайтад "Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай" А/20 дугаар тушаалын гуравдугаар хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, дөрөвдүгээр хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй мэдээллийг мэдээллийн самбарт байршуулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллүүдээ shilen.gov.mn вэб сайтад 5 төрлийн 87 үзүүлэлтээр байршуулан ажиллаж байна. Үүнд: Хууль эрх зүй, даатгалын цахим үйлчилгээ, НД-ын үйлчилгээний төрөл, байгууллагын санхүүгийн статистик мэдээ, цаг үеийн мэдээ мэдээлэл, үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, байгууллагын төсвийн орлого, зарлагын шилэн дансны мэдээллийг харах боломжтой. Мөн shilen.gov.mn-д байршуулах нээлттэй мэдээллийг хагас жилийн байдлаар бүрэн байршуулуулсан.	эл оруулах хяналт тавих ажилтан, Захиргаа, хяналтын хэлтэс) 90
3.2.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуулсад хяналт тавих;	-	- Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. - Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын	Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 100 хувьтай байна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл: -тухай бүр 60 -сар бүр оруулах-18 -бүтэн жилээр мэдээллэх-3 Нийт 81 удаагийн мэдээлэлийг байршуулсан. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл: -тухай бүр -54 - сар бүр оруулах-24 -бүтэн жилээр-3 нийт 81 мэдээлэлийг байршуулсан байна.	ДАМГ (Мэдээлэл оруулах хяналт тавих ажилтан, Санхүү бүртгэлийн хэлтэс) 100

			15-ны өдрийн дотор мэдээлсэн байна.			Байгууллагын үйл ажиллагааны Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үйл ажиллагааны 42948,5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 811981,5 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, нийгмийн даатгалын сангийн орлогын гүйлгээний 91727478.5 мянган төгрөгийн мэдээлэл, 109320119.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээлэлд, Мөн хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 9610,4 мянган төгрөгийн мэдээлэл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээлэлд үйл ажиллагаа 811981,5 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 74598116.7 мянган төгрөг, зарлагын төсөв 219507791.5 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг байршуулсанд хяналт тавьж ажилласан байна.	
Зорилт 3.1: “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
3.1.1.	Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах,	-	- Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь, - Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн баргадуулалтын хувь.	Илэрсэн нийт төлбөр зөрчлийн 81.2 хувийг барагдуулсан.	Шалгалтад 283 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтыг 70-аас доошгүй хувь барагдуулан мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	Газрын хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2025 оны эхний хагас жилд Жаргалант-56, Цагааннуур-17, Бүрэнтогтох-40, Тариалан-73, Тосонцэнгэл-45, Төмөрбулаг-25, Улаан-Уул-34, Цагаан-Уул-109, Шинэ-Идэр-28, Эрдэнэбулган-38, Ханх-24, Цагаан-Үүр-26, нийт 12 сумын 2024 онд тогтоогдсон 515 тэтгэврийн тогтоолт, олголтыг цахим мэдээллийн сан болон үндсэн баримттай тулган шалгасан. Шалгалтаар 53 тэтгэвэрт баримт материал дутуу бүрдүүлсэн зөрчил илэрснийг шийдвэрлэж ажилласан. Хяналт шалгалтын хугацаанд 3 сумын байцаагчид зөвлөмж хүргүүлсэн. НДЕГазрын Хяналт шалгалтын газрын шалгалтын үр дүнгээр илэрсэн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцлөөр тэтгэвэр тогтоолгосон 2 тэтгэвэр авагчтай холбоотой 51262.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 7651.0 мянган төгрөг барагдсан. Төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлж байна. Дотоодын хяналт	(ЗХХ) 90

						шалгалтаар нийт 8 тэтгэвэр авагчтай холбоотой 8094.7 мянган төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчил илэрч 7444.7 мянган төгрөгийг барагдуулж, биелэлт 91.9 хувьтай байна. Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу шимтгэлийн авлага өндөртэй болон төлөвлөгөөнд тусгагдсан 88 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг газрын даргын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт 87 өргөдөл хүсэлтийг үндэслэн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 21 аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой илэрсэн төлбөр зөрчилд 11610.0 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 11610.0 мянган төгрөгийг барагдуулж, актын биелэлт 100.0%-тай байна. Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр 16 аж ахуйн нэгж байгууллага, иргэний зөрчилд 6100.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. 2025 онд тогтоогдсон нийт актын биелэлт 95.9 хувьтай байна.	
3.1.2.	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуу дыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн	Их, дээд коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу “Шидэт урц” төрийн бус байгууллагын 2021-2024 оны баримтыг шалгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг хүргүүлж ажилласан.	(ЗХХ) 91

					зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.		
3.1.3.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	2025 оны 3, 4-р улиралд шалгах хуваарьтай	(ЗХХ)
3.1.4.	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	-Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь -Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, -Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	-	Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна.	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт шалгалтын хүрээнд нийт 1621 ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэгт хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар илүү олгосон 10 даатгуулагчид хамаарах зөрчилд 13,068.1 сая төгрөгийг санд буцаан төлүүлэх акт, тэтгэмжийг дутуу олгосон 18 даатгуулагчид хамаарах зөрчилд 9,303.7 сая төгрөгийг нөхөн олгох, нийт 28 даатгуулагчид хамаарах зөрчилд 22,101.8 сая төгрөгийн акт тогтоож ажилласан байна.	(ЗХХ) 90
3.1.5.	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр	Батлагдсан төсвийн хүрээнд	Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл	2024 онд 2 объектод хяналт шалгалт хийж, зөрчил илрүүлж, албан	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг	Монгол улсын хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 02 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр	(ЗХХ) 95

	бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх;		хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, - Удирдамжийн хугацаанд мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	шаардлага хүргүүлж ажилласан.	шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай" А/78 дугаар тушаал, салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 онд хийгдэх төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу батлагдсан 20 аж ахуйн нэгжээс эхний хагас жилийн байдлаар 10 аж ахуйн нэгжийг хамруулан Зөрчлийн тухай хуулийн дагуу 3 аж ахуйн нэгж байгууллагад 400,0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 1 аж ахуйн нэгжийн 3 даатгуулагчтай холбоотой 1900.2 мянган төгрөгийн нөхөн төлбөрт акт тогтоож ажиллалаа. Актын барагдуулалт 100 хувьтай байна	
3.1.6.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх,	-	- Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь, - НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо,	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т хүргүүлж ажилласан.	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр днг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	НДЕГ-ын Хяналт шалгалтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн хөнгөлөлттэй нөхцлөөр хууль зөрчиж тэтгэвэр тогтоолгосон 2 тэтгэвэр авагчтай холбоотой 51262.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 7651.0 мянган төгрөгийг барагдуулж, актын барагдуулалт 14.9 хувьтай байна. Акт тогтоогдсон 2 иргэн нь гэрээ байгуулж, хуваарийн дагуу сар бүр төлж байна. Дутуу олгосон 4166.0, илүү олгосон 1272.7 мянган төгрөг төлөгдсөн. Эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн 24 сумын 2019-2023 онд шинээр тогтоогдсон 6735 тэтгэврийг 2022-2024 онд бүрэн шалгасан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 12 сумын 2024 онд шинээр тогтоогдсон 515 тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгаж, зөрчил дутагдлыг шийдвэрлэж ажилласан. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудад 56 удаагийн сургалт хийж 2099 даатгуулагч иргэд хамрагдсан. Эхний хагас жилийн байдлаар 88	(ЗХХ) 90

						аж ахуйн нэгж байгууллагыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулсан. Зөрчил дутагдал гаргахгүй ажиллах тал дээр газрын зүгээс онцгой анхаарч тус газрын дарга, хэлтсийн дарга нар болон холбогдох ажилтнууд сумдын байцаагч нарыг арга зүйгээр хангаж 4 удаа цахим сургалт хийсэн. Мөн сумдад шинээр ажилд томилогдсон 4 ажилтныг сурган дадлагажуулах, чадавхжуулах зорилгоор дотоодын сургалтад хамруулсан. Тайлан мэдээг холбогдох дээд газарт хүргүүлж ажиллаж байна.	
3.1.7.	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	-	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах,	Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрлийн барагдуулалтад хяналт тавьж ажилласан.	Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Тэтгэврийн актын үлдэгдэл 2025 оны 06-р сарын 10-ны байдлаар /1218/ 108586.0 мянган төгрөг, НДЕГ-аараас тавьсан актын үлдэгдэл 27370.4 мянган төгрөг, Тэтгэмжийн актын үлдэгдэл 19652.8 мянган төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмжийн актын үлдэгдэл 35254.5 мянган төгрөг, ЭМД-ын үлдэгдэл 1165.5 мянган төгрөг, ҮОМШӨТТТ-ын үлдэгдэл 949.7 мянган төгрөг, бусад авлага 6241.5 мянган төгрөг бүгд 199219.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй /1218/ байна. Өмнөх оны үлдэгдэл 2229923.8 мянган төгрөгөөс 23703.9 мянган төгрөгийг, тайлант онд шинээр үүссэн 17839.7 мянган төгрөгийн авлагаас 7444.7 мянган төгрөгийг барагдуулж ажилласан. Нийт 489926.5 мянган төгрөгөөс 324318.2 мянган төгрөгийг барагдуулж, нийт актын биелэлт 66.2 хувьтай байна. Дотоодын хяналт шалгалтын тайланг хагас бүтэн жилээр НДЕГ-аарт хүргүүлсэн.	(ЗХХ) 85
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.							
Зорилт 4: “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.1.	Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь		- 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа,	2024 онд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, биелэлтийг нэгтгэн авч, дүгнэхэд нийт	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан Засгийн газрын тогтоол 1, ГБХНХЯ-ны сайдын тушаал 1, албан даалгавар 2, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 2, НДЕГ-ын даргын	(ЗХХ) 95

	хүргүүлэх;		удирдлагын газарт хүргүүлсэн байна. -Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн	салбарын хэмжээнд хэрэгжилт 89,4%-тай хэрэгжсэн байна.		албан даалгавар 2, үүрэг даалгавар 1, холбогдох тушаал 6, чиглэл 7, зөвлөмж 8, заавар 2, нийт 32 албан бичгийн хэрэгжилтийг хангаж ажилласан. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, үүрэг даалгаврын 12 биелэлтийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	
4.2.	Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;		-Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ. -Өргөдөл шийдвэрлэлт ийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2024 онд 98.4 %-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд иргэд, байгууллагаас сайн дурын даатгалын залруулга хийх хүсэлт 21, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх хүсэлт 38, тэтгэвэр дахин хянуулах хүсэлт 23, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд 109, бусад 34, нийт 225 өргөдөл гомдол хүлээн авч хуулийн хугацаанд 211 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 14 өргөдөл байна. Шийдвэрлэлт 100.0 хувьтай. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу иргэдээс тэтгэвэр тогтоолгох хүсэлт 705, тэтгэвэр өөрчлөх хүсэлт 56, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмж тогтоолгох хүсэлт 2013, нийт 2774 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Үүнээс 18 тэтгэвэр, тэтгэмжийн өргөдөл хуулийн үндэслэл хангахгүй шалтгааны улмаас буцаагдсан. Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах төвд иргэд даатгуулагчаас 16, НДЕГ-ын "Иргэд олон нийттэй харилцах 311131 утсанд 2, нийт 18 өргөдөл гомдол гаргасан. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж ажилласан. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100,0 хувьтай байна. Хуулийн хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 14 өргөдөл, гомдол нь нийт өргөдөл гомдлын 0.4 хувийг эзэлж байна.	(ЗХХ) 98

4.3.	Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх;		Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна.	Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор ханган ажилласан.	Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргах, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр тайлагнасан байна.	НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дугаар тушаалын дагуу бүтэц орон тоондоо багтаан 3 хэлтсийн зохион байгуулалтаар 47 байцаагч, 6 үйлчилгээний ажилтан, нийт 53 орон тоотой ажиллахаас тайлант хугацаанд 50 албан хаагч ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр улиралд Алаг-Эрдэнэ, Тариалан сумд болон хүний нөөц, хуулийн мэргэжилтний сул орон тооны зарыг Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн боловч тус шалгалтаар орон тоо нөхөгдөөгүй бөгөөд 2 дугаар улирлын захиалгад дахин оруулахаар Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд мэдээлэл оруулан ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар хүний нөөцтэй холбоотой 24 тушаал шийдвэр гарсан байна.	(ЗХХ) 100
4.4.	Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх;		Холбогдох судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна.	Цаг хугацаанд нь үнэн зөв гаргах.	Судалгааг үнэн зөв гаргаж холбогдох баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Газрын албан хаагчдаас нийгмийн даатгалын улсын байцаагчийн тэргүүлэх зэрэгт 1 албан хаагч, итгэмжит зөвлөх зэрэгт 9 албан хаагч, нийт 10 албан хаагчийн судалгааг холбогдох материалын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа удирдлагын газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.	(ЗХХ) 100
4.5.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;		Хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлсэн.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны дэд төлөвлөгөөг баталж, газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна.	Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журмын дагуу 48 албан хаагчид, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 31 албан хаагчид, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 43 албан хаагчид, өдрийн хоолны нөхөх төлбөрийг 45 албан хаагчид Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэрэг олгох журмын дагуу 17 байцаагчид олгосон бөгөөд нийт 262679,4 мянган төгрөгийг	(ЗХХ) 100

						холбогдох хууль, журмын дагуу олгосон байна. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад газрын дарга, дэс түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 байцаагч, нийт 3 албан тушаалтан суралцаж төгссөн.	
4.6.	Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;		Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна.	Салбарын хэмжээнд 100 хувь ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж холбогдох газарт хүргүүлсэн.	Авлигын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Тус газрын нийт 18 эрх бүхий албан тушаалтан 2024 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн бөгөөд холбогдох тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн болно.	(ЗХХ) 100
4.7.	2024 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх;		- Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна.	-	Судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлнэ.	Тус газар нь 2024 онд Алаг-эрдэнэ сумын оршин суугч Б.Оюунцэцэгийн нэхэмжлэлтэй тэтгэвэр тогтоон олгохгүй байгаа талаар шүүхэд гаргасан гомдол, Их-Уул сумын оршин суугч Ц.Батсүрэнгийн нэхэмжлэлтэй тэтгэвэр тогтоон олгохгүй байгаа талаар шүүхэд гаргасан гомдолд хариуцагчаар, Чандмань-Өндөр сумын оршин суугч Э.Мөнхзулын нэхэмжлэлтэй хариуцагч П.Бямбадоржид холбогдуулан гаргасан иргэний хэрэгт гуравдагч этгээдээр тус тус оролцсон. Шүүхийн маргаан нь 2024-2025 онд үргэлжилсэн бөгөөд манай байгууллагын талд шийдвэрлэгдсэн. Хэрэг маргааны судалгааг хүргүүлж ажилласан.	(ЗХХ) 100
4.8.	Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах;		-Хугацаанд нь хүргүүлэх, -Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 75%-тай байв.	Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хугацаанд нь хүргүүлж ажиллаж байна. "Даатгуулагчдыг дэмжих, шимтгэлийн өр авлагыг барагдуулах" нэрлэсэн жилийн ажлын хүрээнд биелэлтийг сар бүрийн 1, 15-ны өдөр биелэлтийг хүргүүлж хэвшсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/75 дугаартай тушаалын дагуу Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн тайлан, биелэлтийг улирал бүрийн дараа сарын 01-ний дотор хүргүүлж байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгөгдсөн	(НДЕГ-ын бүх нэгжид) (ЗХХ, СБХОХ, ТТХ) 94

						үүргийн дагуу 2024 оны санхүүгийн тайлан гаргах ажлын хүрээнд 2024 оны 1-12 сарын Төрийн болон Хаан банкаар нэмэлт нэрээр гарсан 7796 гүйлгээгээр 3752,1 сая төгрөгийн, гүйлгээг нэг бүрчлэн тулгаж "Sicos" программд бүрэн оруулсан.		
Зорилт 4.1: "Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:								
4.1.1.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх сургалтыг байгуулах;		2	-Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, -Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна.	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	НДГ-ын нийт албан хаагчдад 2025 оны 05-р дугаар сард "Авлига ашиг сонирхолын зөрчил, урьдчилан сэргийлэх арга зам" сэдвийн хүрээнд Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Отгончимэг "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Р.Машбат, нар сургалт зохион байгууллаа. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтээс зохион байгуулсан сургалтад байгууллагын эрх бүхий 18 албан тушаалтан хамрагдсан. Хөвсгөл аймаг дахь Шүүхийн тамгын газрын шүүгчийн туслах П.Ганбүргэд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сургалтыг газрын нийт 23 албан хаагчдад орсон. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Р.Төрбулагийн "Авлигын гэмт хэрэг ба авлигын хор хөнөөл" сэдэвт сургалтад магадлагч эмч нар танхимаар, ЭММЗөвлөлийн гишүүд болон эмч нарт авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭММТЗ-өөс 2 удаа зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан. Аймгийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчид болон газрын дэргэдэх ЭММЗөвлөл болон МХШЗөвлөлийн бүрэлдэхүүнээс баталгаа авч гарын үсэг зуруулан ажилласан байна. Мөн тус газрын нийт 48 албан хаагчдад авлига	(ЗХХ) 100

						ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дотоодын сургалтыг 1 удаа зохион байгуулж ажилласан. Тус газрын 18 албан хаагч 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн. 2025 онд газрын албан хаагчдаас авлига, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй болно.									
4.1.2.	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;		- Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, -Албан хаагчдыг 100% хамруулсан байна.	Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 8 удаагийн сургалтад 44 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна.	Тус газар нь хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх ажилтнуудыг сургаж хөгжүүлэх чиглэлд үе шаттай арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд: Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Тосонцэнгэл, Галт, Төмөрбулаг, Жаргалант, Улаан-Уул, Их-Уул сумдад шинээр томилогдсон албан хаагчдыг чадавхжуулах танхимын сургалтад хамруулж, газрын албан хаагчид арга зүйн зөвлөмжийг өгч ажилласан. Мөн газар, хэлтэс, сумдын нийт 42 албан хаагчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлига ашиг сонирголоос ангид байх, урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг сахиж ажиллах чиглэлээр 3 удаагийн дотоодын сургалтыг зохион байгуулсан. Эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын дарга, хэлтсийн дарга нар газрын албан хаагчдад танхимаар, 23 сумын байцаагч нарт цахимаар сургалт хийсэн. 2025 оны 02 дугаар сард ГБХНХЯ-ны нийгмийн хамгааллын салбарын ажилтны зөвлөгөөнд газар хэлтэс, сумдын нийт 44 албан хаагч хамрагдаж оролцсон байна.	(ЗХХ) 93								
4.1.3.	Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;		- Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, - 30-аас	Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 398 удаагийн сургалтад аж ахуйн нэгжийн 12251 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулав.	Аймгийн хэмжээнд 375 ажил олгогч, 13100 иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг	2025 оны хагас жилийн байдлаар ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар 170 удаагийн сургалт хийж, нийт 12389 иргэд даатгуулагчид хамрагдсан байна.	(ЗХХ) 98								
						<table><tr><td>№</td><td>Сургалтын хамрах хүрээ</td><td>Сургалтын тоо</td><td>Хамрагдсан даатгуул</td></tr><tr><td></td><td></td><td></td><td></td></tr></table>	№	Сургалтын хамрах хүрээ	Сургалтын тоо	Хамрагдсан даатгуул					
№	Сургалтын хамрах хүрээ	Сургалтын тоо	Хамрагдсан даатгуул												

			доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, -Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна.		танхимаар болон цахимаар зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна.				агчийн нийт тоо		
						1	Ажил олгогч, албан байгууллага	56	2099		
						2	Баг, хороод /тэтгэвэр тогтоолгох эрх үүсч буй иргэд/	34	1109		
						3	Оюутан, сурагч	5	189		
						4	малчид	75	8992		
							Нийт	170	12389		

Зорилт 4.2: “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.2.1.	а) Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилт ханган ажиллах; б) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх	-	а) Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна. б) -Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан барьер үсгээр танилцуулга бэлдэх -НДгазраас бэлтгэн гаргаж байгаа бичлэг лайвыг дохионы хэлээр түгээх -хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн	Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан.	Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна.	Тус газар нь үйлчилгээний болон ажлын байрны стандартыг хангах зорилгоор үйлчилгээний зааланд “даатгуулагчийн булан” бий болгож, ширээ сандал тавьж, санал хүсэлт хүлээн авах хайрцаг байрлуулсан. Угтах үйлчилгээг хийж хэвшсэн. Газрын албан хаагчид: Шуурхай-Чирэгдэлгүй-Сэтгэл ханамжтай-Соёлтой үйлчилгээ гэсэн үйлчилгээний стандартад нийцэж ажиллаж байна. Мөн албан хаагч ажилтнууд ажлын байран дээр жигд хувцас өмсөж байна. Үйлчилгээний орчны стандартыг хангах чиглэлд анхаарч ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан барьерийг даатгуулагчийн буланд байршуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд саадгүй оролцох боломжийг бүрдүүлэх, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд байгууллагын гадна үүдний хэсэгт 2.9 сая төгрөгийн өртөгтэй налуу зам барьсан. Архивын баримтыг хадгалах, хамгаалах, багтаамжийг нэмэгдүүлэх зориулалтаар архивын өрөөг шинээр барьсан.	(ЗХХ) 90
--------	--	---	---	--	--	---	-------------

			үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх																																												
4.2.2.	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;	-	Дуудлага алдалт 10% ба 15%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна		Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна. Дуудлага алдалтыг 10-15 хувьд барьж ажиллана	Тус газар нь иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө өгөх CallPro-75091000 үйлчилгээг хэрэгжүүлж ажиллаж байна. Үйлчилгээг төрөл тус бүрээр задалвал: <table><tr><td>Операторийн нэр</td><td>Ирсэн дуудлага</td><td>Хариулсан дуудлага</td><td>Алдсан дуудлага</td><td>Алдсан дуудлагын хувь</td></tr><tr><td>НДШ</td><td>182</td><td>161</td><td>21</td><td>11%</td></tr><tr><td>Санал хүсэлт</td><td>92</td><td>88</td><td>4</td><td>4%</td></tr><tr><td>Сайн дурын даатгал</td><td>345</td><td>309</td><td>36</td><td>10%</td></tr><tr><td>Тэтгэмж</td><td>1131</td><td>995</td><td>136</td><td>12%</td></tr><tr><td>Тэтгэвэр</td><td>210</td><td>191</td><td>19</td><td>9%</td></tr><tr><td>Цахим үйлчилгээ</td><td>11</td><td>11</td><td>0</td><td>0%</td></tr><tr><td>Нийт тоо</td><td>1971</td><td>1755</td><td>216</td><td>11%</td></tr></table> 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1971 дуудлага ирснээс 1755 дуудлагад хариу өгч ажилласан байна. Нийт дуудлагын 11 хувийг алдсан үзүүлэлттэй байна.	Операторийн нэр	Ирсэн дуудлага	Хариулсан дуудлага	Алдсан дуудлага	Алдсан дуудлагын хувь	НДШ	182	161	21	11%	Санал хүсэлт	92	88	4	4%	Сайн дурын даатгал	345	309	36	10%	Тэтгэмж	1131	995	136	12%	Тэтгэвэр	210	191	19	9%	Цахим үйлчилгээ	11	11	0	0%	Нийт тоо	1971	1755	216	11%	(ЗХХ, СБХОХ, ТТХ) 90
Операторийн нэр	Ирсэн дуудлага	Хариулсан дуудлага	Алдсан дуудлага	Алдсан дуудлагын хувь																																											
НДШ	182	161	21	11%																																											
Санал хүсэлт	92	88	4	4%																																											
Сайн дурын даатгал	345	309	36	10%																																											
Тэтгэмж	1131	995	136	12%																																											
Тэтгэвэр	210	191	19	9%																																											
Цахим үйлчилгээ	11	11	0	0%																																											
Нийт тоо	1971	1755	216	11%																																											
4.2.3.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах;	-	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг "Рийл" улиралд 3-аас доошгүй удаа; "Постер" сард 3-аас доошгүй удаа; "Видео контент"	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг хангаж ажилласан.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгааг "Рийл" 10 удаа, Постер 10 удаа, Видео контент 4 удаа, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээ мэдээлэл өгч түгээх ажлыг гүйцэтгэсэн байна. Нийгмийн	Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг "Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах" нэрлэсэн жилийн хүрээнд ажил олгогч, иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдлэгийг нэмэгдүүлэх, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх үүднээс шууд "LIVE"-ыг Нийгмийн даатгалын газрын page хуудсаар 6 удаа иргэд даатгуулагчдад дараах сэдвийн хүрээнд хүргэсэн байна. Үүнд: Сайн дурын даатгал, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, Архивын лавлагаа, Өндөр насны тэтгэвэр, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, Тэтгэмжийн даатгал гэсэн сэдвийн	(ЗХХ) 100																																								

			улиралд 1 удаа; -Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа;		даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна.	хүрээнд шууд бичлэгийг хүргэж 230 лайк, 55 комент, 20422 хандалтийг тус тус авсан байна. Мөн 10 удаагийн видео бичлэг байршуулж, 301 лайк, 27 комент, 26510 хандалтыг авсан. Нийгмийн даатгалын газрын page хуудсаар Иргэд даатгуулагчдад чиглэсэн сонирхол татахуйц 31 постерийг оруулж 416 лайк, 453 удаа хуваалцаж, 27876 хандалтыг авсан байна. Хөвсгөл аймгийн иргэд, даатгуулагчдад мэдээ мэдээллийн интертаймент сайт "Khoimor.mn" сайтаар -Хөвсгөл аймгийн НДГ-ын үйл ажиллагааны танилцуулга контент, Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалтын талаар рийл, -Тэтгэврийн 6 хувийн нэмэгдлийн талаар рийл, -Малчин нөхцөлөөр өндөр настны тэтгэвэр тогтоолгох тухай сэдвийн хүрээнд контент, -Малчны өндөр насны тэтгэврийн анхаарах асуудлууд сэдвийн хүрээнд ярилцлага хийсэн байна. Дээрх контент, рийл, ярилцлагыг нийтлэн түгээж 991 лайк, 61 сэтгэгдэл, 365 удаа хуваалцаж, 53700 хандалтыг авсан байна. ГБХНХЯ, НДЕГ-ын цахим хуудасны мэдээ мэдээллийг өөрийн цахим хуудсаар тогтмол дамжуулан нийт албан хаагчдаар өдөр тутам түгээлгэн ажиллаж байна.	
Зорилт 4.4: "Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.4.3.	Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах;		Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах		Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.	2024 онд Нийгмийн даатгалын үйлчилгээнд шинэ программ нэвтрүүлж системийн шинэчлэл хийгдсэн. Үүнтэй холбогдуулан мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтнүүдэд МТТ-өөс эрхийн тохиргоо хийх admin эрхийг олгосны дагуу газрын болон сумын 41 байцаагчид Sicos программд нэвтрэх эрхийн тохиргоог албан үүргийнх нь хүрээнд тохируулж, хүн тус бүрийн программд нэвтрэх нэр, нууц үгийг албаны и-мэйлээр нь илгээж баталгаажуулсан ба хүн	(МТТ) (ЗХХ) 90
			МТТ-өөс хүргүүлсэн		МТТ-өөс зохион байгуулсан ажлын		

			албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх		гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.	бүрийн нууц үгийг улиралд нэг удаа дахин шинэчилж байна. Байцаагч нар программ хангамжийг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан газрын 21 албан хаагчдыг арга зүйгээр хангаж ажиллаж байна.	
--	--	--	---	--	---	--	--

Тав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1		2	3	4	5	6	7
5.1	Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох;	Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна. -Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна.	Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна	Үндэсний бичигт хөрвүүлэх	Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолын дагуу Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд тус газар нь Мөрөн сумын Ерөнхий боловсролын Эрдмийн далай цогцолбор сургуулийн багш Н.Батцэцэг хамтран ажиллаж, үндэсний бичгийн боловсролыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан 7 хоног бүрийн Лхагва гарагт газрын нийт албан хаагчдад сургалтыг танхимаар сумдын байцаагч нарт цахимаар нэг удаагийн оролтоор 2 цаг орж 10 удаа зохион байгуулж суралцсан. Үндэсний бичигт хөрвүүлэх анхан шатны мэдлэг, арга зүйг эзэмшсэн.	2025.01.02 2025.06.15	95%
5.2	Нийгмийн байгууллагын даатгалын сургалт, зөвлөгөөнд хамрагдах	Сургалт, зөвлөгөөнд бүрэн хамрагдсан байна.	Сургалт-зөвлөгөөнд 14 удаа хамрагдсан.	Зохион байгуулагдсан хугацаанд	НДЕГ-ын болон Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, бусад холбогдох сургалт зөвлөгөөнд 18 удаа хамрагдсан байна. ЭККО-ФАРМ төслийн хүрээнд зохион байгуулагдсан Жендер ба бодлого төлөвлөлт сэдэвт удирдах түвшний албан	2025.01.02 - 2025.06.15	100%

					хаагчдад зориулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.		
--	--	--	--	--	--	--	--

